



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 03 дугаар сарын 02 өдөр

Дугаар 06

Хэрлэн сум

VI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 06 дугаар хуралдаан 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 76,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Мал, амьтны сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах талаар мэдээлэл танилцуулах,

Мал эмнэлгийн газар

2.Малын гоц халдварт өвчний нөхцөл байдлын талаарх мэдээлэл танилцуулах,

Мал эмнэлгийн газар

3.Дорнод аймгийн 2023 оны гал түймрийн нөхцөл байдал, аймгийн Засаг даргын 2023 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгавар танилцуулах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

4.Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлын талаар танилцуулах,
Байгаль, орчин аялал жуулчлалын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа-д:

1.1.Мал, амьтны сэг зэмийн устгал, халдваргүйтгэлийн ажилд хяналт тавьж ажиллах,

Байгаль, орчин аялал жуулчлалын газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Гантулга-д:

1.2.Үхсэн зэрлэг амьтны судалгааг гаргаж, сэг зэмийн устгал, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг танилцуулах,

/  / М.Бадамсүрэн
/  / Хур Г.Нармандах

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа,
Байгаль, орчин аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын
дарга нарт:

1.3.Мал, амьтны сэг зэм устгалыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг мэргэжлийн байгууллагуудын бүрэлдэхүүнтэй байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамжийг боловсруулж батлуулах,

Хоёр.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа-д:

2.1.Цагаанаар зудархуу ангилалд байгаа Баянтүмэн, Булган, Сэргэлэн, Цагаан-Овоо, Хөлөнбуйр сумдын мал, амьтны сэг зэмийн устгал, халдваргүйтгэлийн ажилд 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх тухай аймгийн Засаг даргын захирамжийг боловсруулж батлуулах,

2.2.Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар малчин иргэдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах, Хөлөнбуйр суманд ажлын хэсэг томилж ажиллуулах,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1.Аймгийн Засаг даргын 2023 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаврыг аймгийн Онцгой комиссын гишүүдэд албан бичгээр хүргүүлэх,

Байгаль, орчин аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга-д:

3.2.Хүний амь нас эрсэдсэн, мал, эд хөрөнгө шатсан, дархан цаазат газар шатсан, хил давсан ой, хээрийн түймрийн эзэн холбогдогч, хохирлыг тогтооход хяналт тавьж ажиллах,

3.3.Хил хамгаалах байгууллагуудад хилийн бүсэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай албан бичгээр чиглэл хүргүүлэх,

3.4.Багийн дарга, байгаль хамгаалагч нарт ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх шатахууны зардлыг 2 дахин нэмэгдүүлэх,

3.5.Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын цэгүүдийг 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн ажиллуулах,

Байгаль, орчин аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Байгаль хамгаалалтын захиргааны
дарга Б.Эрдэнэбаяр нарт:

3.6. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын бэлтгэл бэлэн байдлыг хангуулах 4 ажлын хэсгийг Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Байгаль хамгаалалтын

/  / М.Бадамсүрэн
/  / Хур Г.Нармандах

захиргааны бүрэлдэхүүнтэй байгуулж сумдад томилон ажиллуулах, ажлын хэсгийн дүгнэлтийг 2023 оны 03 дугаар сарын 20-ны дотор дүгнэлтийг танилцуулахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА

М.БАДАМСҮРЭН

ОРЛОГЧ ДАРГА
ХУРАНДАА

Г.НАРМАНДАХ